



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ЦАГ УУР, ОРЧНЫ
ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР**

Жуулчны гудамж 5, 4 дүгээр хороо,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 41 52, Факс: (976-11) 32 66 11,
Цахим шуудан: info@namem.gov.mn

2026. 04. 23 № 05/319
танай _____-ны № _____-т

Зөвлөмж хүргүүлэх тухай

Орхон аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн урьдчилан мэдээлэхийн инженер Д.Энх-Эрдэнэгээс Монгол Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлэгт гаргасан “Орхон аймгийн УЦУОШТ-д хяналт шалгалт хийж, дарга С.Отгонбаатар, Цаг уур технологи, мэдээлэл үйлчилгээний хэлтсийн дарга Д.Оюунбат, Захиргаа төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Хандмаа нарын хууль бус үйлдэлд хариуцлага тооцож өгнө үү” гэх агуулга бүхий гомдлыг шилжүүлснийг Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.5-д заасны дагуу заасны дагуу дотоод хяналт, шалгалт хийж дараах зөвлөмжийг танд хүргүүлж байна. Үүнд:

1. Хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу Эрдэнэт-Овоо цаг уурын өртөөний техникчийн цаг нөхөх алба хаагчдыг 13.30-20.30 цагт ээлжлэн ижил тэгш байдлаар ажиллуулах;

2. Хөдөлмөрийн тухай хуулийн 84.1 дахь заалтыг баримтлан “Эрдэнэт-Овоо” цаг уурын өртөөний техникчийн цаг нөхөх ажилтны ажлын цагийг зөв зохион байгуулж, илүү цагаар ажилласан бол ажилтныг нөхөн амруулах эсхүл түүний дундаж цалин хөлсийг нэг аравны тав дахин, түүнээс дээш хэмжээгээр нэмэгдүүлж олгох;

3. Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд заасан төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, нийтлэг шаардлагыг мөрдөн ажиллаж, хамт олны дотор ажил хэрэгч уур амьсгалыг бий болгох, харилцан бие биеэ хүндэлсэн ажиллах орчныг бүрдүүлэх зэрэг соён гэгээрүүлэх ажлыг удирдан манлайлан сургалт сурталчилгааны ажлыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулж тайланг 2026 оны 06 дугаарын сарын 15-ны дотор ирүүлэх.

ХЯНАЛТ, ДОТООД
АУДИТЫН ХЭЛТСИЙН ДАРГА



Х.ОЮУНБИЛЭГ

1526020278